



## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН-  
ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Г.ЛУВСАНРАГВА ТАНАА

2024-03-25

№ 110

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 203 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 1.5 дахин буюу 486.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны дундуур төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, тогтмол зардлын болон бараа үйлчилгээний үнэ тарифын өссөнтэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

### Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 241.6 сая төгрөгийг магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулаагүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулахаар баталж санхүүжүүлсэн нь тайлант үеийн удирдлагын шийдвэр гаргасан чухал асуудал, нөлөө бүхий ажил гүйлгээ байлаа.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 8 хөтөлбөр, 31 зорилт, 148 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/15/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Дундговь аймаг  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Наранцацрал  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Narantsatsralkh@audit.gov.mn](mailto:Narantsatsralkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Ихбаяр  
Утас: 70593113  
Цахим хаяг: [ikhbayard@audit.gov.mn](mailto:ikhbayard@audit.gov.mn)

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ  
Утас: 70593113  
Цахим хаяг: [oyunerdenet@audit.gov.mn](mailto:oyunerdenet@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал .....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
4.5.1 Завсрын аудитын талаар .....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208. Цахим хаяг: dundgovia@audit.gov.mn

2024-03-25 № 110

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН- ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.ЛУВСАНРАГВА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 203 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 1.5 дахин буюу 486.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны дундуур төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, тогтмол зардлын болон бараа үйлчилгээний үнэ тарифын өссөнтэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 241.6 сая төгрөгийг магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулаагүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулахаар баталж санхүүжүүлсэн нь тайлант үеийн удирдлагын шийдвэр гаргасан чухал асуудал, нөлөө бүхий ажил гүйлгээ байлаа.

### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 8 хөтөлбөр, 31 зорилт, 148 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	659,076.5	678,011.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	118,183.9	154,182.6
33	АВЛАГА	249,198.3	231,739.4
35	БАРАА МАТЕРИАЛ	175,919.3	176,314.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	115,775.0	115,775.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,887,587.9	3,068,133.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,887,587.9	3,068,133.1
39200	Биет хөрөнгө	2,871,684.5	3,049,352.2
39300	Биет бус хөрөнгө	15,903.4	18,780.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,546,664.4	3,746,144.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,960.1	21,964.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,960.1	21,964.6
41300	Өглөг	17,960.1	21,964.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,528,704.2	3,724,179.6
51	Засгийн газрын хувь оролцоо	3,528,704.2	3,724,179.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	430,159.4	430,159.4
51200	Хуримтлагдсан үр дүн	2,881,222.8	3,076,698.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	217,322.0	217,322.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,546,664.4	3,746,144.3

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,024,197.4	1,510,207.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	176,841.1	204,294.5
110	Орлогын албан татвар	121,788.8	160,138.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	121,788.8	160,138.2
113	Хөрөнгийн албан татвар	29,793.4	32,047.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	25,258.9	12,108.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,940.6	201,474.9
120	Нийтлэг татварын бус орлого	51,940.6	201,474.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	795,415.6	1,104,438.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,030,873.3	1,215,808.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,030,873.3	1,215,808.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	747,555.8	923,611.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,929.9	382,621.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,175.7	48,261.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,060.9	36,214.2
2104	Хангамж, бараа материалын зардал	80,786.0	48,274.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,826.0	24,608.8
2107	Томилолт, зочны зардал	11,032.6	18,111.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,918.6	3,691.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	312,826.1	361,827.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	283,317.5	292,196.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(6,675.9)	294,399.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	4,025.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,432,985.0	104,495.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(3,439,661.0)	193,929.4

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,020,836.3	7,020,836.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-52,471.2	-52,471.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,968,365.2	6,968,365.2
9	Тайлант үеийн үр дүн	-3,439,661.0	-3,439,661.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,528,704.2	3,528,704.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,528,704.2	3,528,704.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,546.0	1,546.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,530,250.2	3,530,250.2
19	Тайлант үеийн үр дүн	193,929.4	193,929.4
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,724,179.6	3,724,179.6

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,052,924.6	1,428,316.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	176,841.1	204,294.5
110	Орлогын албан татвар	121,788.8	160,138.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	121,788.8	160,138.2
113	Хөрөнгийн албан татвар	29,793.4	32,047.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,668.9	8,029.5
1181	Газрын төлбөр	4,590.1	4,078.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,135.2	120,481.7
120	Нийтлэг татварын бус орлого	82,135.2	120,481.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	793,948.3	1,103,539.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	783,104.1	929,223.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	783,104.1	929,223.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	671,808.8	880,858.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,800.6	382,881.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,530.9	48,270.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,539.0	30,064.8
2104	Хангамж, бараа материалын зардал	44,005.1	48,286.1
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,678.7	25,576.8
2107	Томилолт, зочны зардал	11,032.6	18,005.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,522.4	248,945.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,699.4	78,827.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	111,295.4	48,365.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	269,820.5	499,092.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	343,624.9	438,093.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	343,624.9	438,093.5
2200	Дотоод эх үүсвэрээр	343,624.9	438,093.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(343,624.9)	(438,093.5)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(92,300.0)	(25,000.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	92,300.0	25,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(166,104.4)	35,998.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	284,288.4	118,183.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	118,183.9	154,182.6



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,549,310.1</b>	<b>1,370,946.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>952,221.7</b>	<b>920,252.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>911,217.8</b>	<b>879,250.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,605.8	382,881.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,724.1	48,270.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,905.8	253,414.5
2104	Хангамж, бараа материалын зардал	40,259.9	47,823.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,710.0	59,664.9
2107	Томилолт, зочны зардал	17,865.4	16,037.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,982.5	2,471.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,854.6	68,686.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41,003.9</b>	<b>41,002.7</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,003.9	41,002.7
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>513,098.4</b>	<b>425,693.5</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>83,990.0</b>	<b>25,000.0</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,549,310.1</b>	<b>1,404,451.6</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>402,468.1</b>	<b>402,468.1</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>959,644.4</b>	<b>909,370.1</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>187,197.6</b>	<b>93,613.4</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	87,406.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	120,911.9

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>19,069.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19,069.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>13,860.7</b>
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216.7
2104	Хангамж, бараа материалын зардал	463.0
2107	Томилолт, зочны зардал	1,968.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,220.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,993.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,209.0</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,209.0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>19,069.7</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,069.7

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг дарга нь эрхэм зорилгоо “Ардчиллыг бэхжүүлэн, нийгмийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлж, сумын нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн өргөн оролцоотойгоор шийдвэрлэн, тэдний нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой, тэнцвэртэй хөгжлийг хангахад оршино” гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад өөрчлөлт ороогүй. Харин байгууллагуудын хувьд төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой дараах тогтоолуудад өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт”-ыг шинэчлэн тайлант оноос дагаж мөрдөхөөр,
- Засгийн газрын “Журам батлах тухай” 2018 оны 382 дугаар тогтоолын нэмэлт өөрчлөлтүүд,
- Засгийн газрын 2023 оны 240 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2023 оны 241 дугаар тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Төсөв захирагч нарын ахмадын сангийн тайланг үндсэн тайланд нэгтгэж тайлагнах тухай чиглэлийг аймгийн СТСХ-ээс албан бичгээр ирүүлсэн байна. Уг чиглэлийн дагуу ахмадын сангийн тайланг үндсэн тайланд нэгтгэн тайлагнажээ.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 199,479.8 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	118,183.9	154,182.6	35,998.7
Авлага	249,198.3	231,739.4	(17,458.9)
Бараа материал	291,694.3	292,089.1	394.8
Үндсэн хөрөнгө	2,887,587.9	3,068,133.1	180,545.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,546,664.4</b>	<b>3,746,144.2</b>	<b>199,479.8</b>
Өр төлбөр	17,960.1	21,964.6	4,004.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,528,704.3	3,724,179.6	195,475.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,546,664.4</b>	<b>3,746,144.2</b>	<b>199,479.8</b>

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтэд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан данс үндсэн хөрөнгө болон Засгийн газрын хувь оролцооны данс байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 180,545.2 мянган төгрөгөөр өссөн нь сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгө бөгөөд тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 460,318.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгасантай холбоотой байна.

Мөн авлагын дансны үлдэгдлийг 231,739.4 мянган төгрөгөөр тайлагнаснаас дийлэнх хувь нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,724,179.6 мянган төгрөг болж 195,475.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

### 3.4.2 Орлого бүрдүүлэлт

Сайхан-Овоо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 84 дугаар тогтоолоор тайлант онд 249,642.3 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 228,509.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 8.5 хувиар тасалсан байна.

#### Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татвар	126,500.0	154,850.9	28,350.9	122.4
2	Үйл ажиллагааны орлого	13,000.0	5,287.3	(7,712.7)	40.7
4	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,400.0	2,564.7	1,164.7	183.2
5	Бууны албан татвар	840.0	1,020.0	180.0	121.4
6	Малын тоо толгойн албан татвар	56,802.3	28,463.2	(28,339.2)	50.1
7	Улсын тэмдэгтийн хураамж	1,600.0	665.2	(934.9)	41.6
8	Түгээмэл тархцатай ашигт малтмал ашигласны төлбөр	1,500.0	-	(1,500.0)	-
9	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15,000.0	7,364.3	(7,635.7)	49.1
10	Газрын төлбөр	3,700.0	4,078.9	378.9	110.2
11	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	5,000.0	-	(5,000.0)	-
12	Хадгаламжийн хүүгийн орлого	21,000.0	19,757.1	(1,242.9)	94.1
	<b>Татварын бус</b>	<b>246,342.3</b>	<b>224,051.6</b>	<b>(22,290.8)</b>	<b>91.0</b>
	Хүү торгууль	3,300.0	4,457.8	1,157.8	135.1
	<b>Татварын бус</b>	<b>3,300.0</b>	<b>4,457.8</b>	<b>1,157.8</b>	<b>135.1</b>
	<b>Нийт дүн</b>	<b>249,642.3</b>	<b>228,509.4</b>	<b>(21,132.9)</b>	<b>91.5</b>

Дараах нэр төрлийн орлого материаллаг дүнгээр тасарсан байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлого 7,712.7 мянган төгрөгөөр тасарсан нь 2022 оны ноос, арьс ширний урамшууллын орлого ороогүй;
- Малын тоо толгойн албан татвар 15,803.1 мянган төгрөгөөр тасарсан нь өвөлжилт хүндэрч, отор нүүдэл ихэссэнтэй холбоотой малчид татвараа төлөөгүй мөн өмнөх оны авлага барагдаагүй он дамжсан;
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 7,635.7 мянган төгрөгөөр тасарсан нь хог тээврийн автомашин эвдэрч зарим саруудад хог ачилт хийгдээгүйгээс айл өрхийн хогийн төлбөр бүрэн төвлөрөөгүй;
- Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж биелээгүй нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2 тэх агнах зөвшөөрөл олгогдсон боловч ан агнуурын компани ан хийгээгүй, мөн сум татварын байцаагчгүй, аймгийн Татварын хэлтсээс хавсран гүйцэтгэж байна.

Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын орлого материаллаг дүнгээр давж биелсэн нь тайлант онд төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, жилийн эцэст хэмнэгдсэн цалингийн сангаас албан хаагчдад мөнгөн урамшуулал олгогдсонтой холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сайхан-Овоо сумын ИТХ-ын 2022 оны 65 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,366,361.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,366,361.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Сайхан-Овоо сумын ИТХ-ын 2023 оны 84 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 182,948.4 мянган төгрөгөөр нэмж, 1,549,310.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төрийн албан хаагчдын цалин хөлсийг Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дугаар тогтоолоор 2023 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс нэмсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 1,549,310.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 952,221.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 513,098.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 83,990.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 402,468.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 959,644.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 96,490.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 90,707.6 мянган төгрөгийг урьд оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 402,468.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 909,370.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 92,613.4 мянган төгрөг, урьд оны эхний үлдэгдлээс 87,406.6 нийт 1,491,858.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 56,606.8 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөнөөс 2,283.2 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлого 36,006.6 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөнөөс 1,593.4 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, туслах үйл ажиллагааны орлогод мал хамгаалах, байгаль хамгаалах сангийн орлого, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,370,946.3 мянган төгрөг буюу 88.5 хувьтай байгаа нь урсгал зардал 31,968.9 мянган төгрөг, хөрөнгийн зардал 87,404.9 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээл 58,990.0 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 2,153.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 13,667.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5,402.7 мянган төгрөг, нийт 19,069.7 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна. Үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 216.7 мянга, хангамж, бараа материалын зардалд 463.0 мянга, томилолт зочны зардалд 1,968.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 1,220.0 мянга, бараа үйлчилгээний зардал 9,993.0 мянга, нийт 13,860.7

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

мянган төгрөгийг зарцуулсан байна. Үлдэгдэл 5,209.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг дарга 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаас нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,215,808.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,158.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,118.6 мянган төгрөгөөр тогтоосон.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланг түүвэрлэн шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Харин дээрх хуулийн хүрээнд бараа, үйлчилгээний бусад зардлаас 15,168.4 мянга, эд хөгжил, урсгал засварын зардлаас 4,045.1 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг дарга нь 2023 онд нийт 467,437.6 мянган төгрөгийн 56 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан байна.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мөн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг шалгахад зөрчил илрээгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг дарга болон санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд алдаа, зөрчил илрээгүй. Харин санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 21,023.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 14,728.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, 1 заалт бүхий 5,000.0 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна. Акт албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	7	21,023.1	6	14,655.1	1	6,368.0	69.7
Албан шаардлага	6	14,728.1	6	14,728.1			100.0
Зөвлөмж	1	5,000.0	1	5,000.0			100.0
<b>Нийт</b>	<b>14</b>	<b>40,751.2</b>	<b>13</b>	<b>34,383.2</b>	<b>1</b>	<b>6,368.0</b>	<b>89.9</b>

Өмнөх аудитаар өгөгдсөн төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн тухай хариуг Төрийн аудитын газарт албан бичгээр болон санхүүгийн тайлангийн аудитын "<https://fas.audit.mn/>" системээр ирүүлсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэх мөн татварын орлогын бүрдүүлэлтэд хяналт тавихаар шийдвэрлэлээ.

#### 5. Аудитын илрүүлэлт

##### 5.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар нийт 275,931.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 223,566.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 52,365.3 мянган төгрөгийн зөвлөмжийг өгсөн.

*Залруулсан алдаа:*

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 223,566.4 мянган төгрөгийн зардлыг зүйлийг зөрүүлэн тайлагнасан. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Залруулаагүй алдаа:*

Аудитаар нийт 223,566.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 1 заалт зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**5.1.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орон нутгийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:**

Орон нутгийн татварын 7 нэр төрлийн орлогыг 52,365.3 мянган төгрөгөөр тасалсан. Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.19-т /Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах/, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т /Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1-т /Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/ гэж заасныг хэрэгжүүлээгүй байна. Дээрх зөрчил нь гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хэрэгжүүлэх боломжгүйд хүргэх үр дагавартай байна.

**Өгсөн зөвлөмж:**

Татварын болон татварын бус орлогыг төлөвлөхдөө тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, орлогын нэр төрлийг бүрэн төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>5</b>		<b>1</b>			

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 247,250.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,797.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 241,559.3 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 57.0 хувийг залруулагдаагүй, 43.0 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.